

## “ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

№02

Улаанбаатар хот

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг хуралдуулах тухай авч хэлэлцээд ТОГТООХ нь:

1. “Талын гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 14.00 цагаас тус компанийн хурлын танхимд хуралдуулахаар, бүртгэлийн өдрийг 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгохоор тус тус тогтоосугай.
2. Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
  - Хянан шалгагчийн тайлан
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүнийг сонгох
  - Төлөөлөн удирдах зөвлөл, Хянан шалгагчийн 2023 оны цалин, урамшуулал, зардлын төсвийг батлуулах.
3. Компанийн тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг зохих журам дүрмийн дагуу бүрэн хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга У.Батсуурь, Гүйцэтгэх захирал С.Цэрэндондов нарт даалгасугай.

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

  
У.БАТСУУРЬ